314

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.09.10 № 15

БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

Боловсролын салбарын тоон
мэдээллийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, 2024 оны 10 дугаар сарын 1-нээс Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган хуралдаж, 2025 оны Монгол Улсын төсвийг хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон, төсвийн тодотголоор батлагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарын болон боловсролын салбарын цалингийн нийт сан, түүний дэлгэрэнгүй задаргааг хүснэгтээр ирүүлэх (үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэтгэмж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл болон бусад урамшууллыг нэгтгэсэн дэлгэрэнгүй задаргаа);
2. Монгол Улсын Засгийн Газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа Монгол Улсын 2025 төсвийн тухай хуульд цалингийн нийт санг хэрхэн тусгасан, түүний дэлгэрэнгүй задаргааг хүснэгтээр ирүүлэх (үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэтгэмж, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл болон бусад урамшууллыг нэгтгэсэн дэлгэрэнгүй задаргаа);
3. Монгол Улсын Засгийн Газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн хүрээнд Боловсролын салбарын цалингийн нийт санг хэрхэн төсөөлж байгаа тухай мэдээллийг ирүүлэх;
4. 2024 оны байдлаар Боловсролын салбарт төсвөөс цалинжиж байгаа нийт ажилтан, албан хаагчдын тоог нэгдсэн байдлаар ирүүлэх;

(Ингэхдээ: Төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр, Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр, Соёл, урлаг, биеийн тамир,

20240034

спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр, Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалтны тоог зэрэглэл тус бүрээр гаргаж өгнө үү.)

5. Асуултын (4) дүгээрт заагдсан боловсролын салбарын төсвөөс цалинжиж байгаа нийт ажилтан, албан хаагчдын тоо 2025 онд хэд байхаар тусгасан, 2026, 2027, 2028 онуудад хэд байхаар тооцож буйгаа ангилал, зэрэглэл тус бүрээр ирүүлэх;

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.МӨНХТУЯА

20240024